


СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨТӨЧ НОМ



MONTSAMEimages
Baramsal Chadraabal

СЭЛЭНГЭ

АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

1921 оны ардын хувьсгалын өлгий нутаг болсон бөгөөд 1931 онд "Газар тариалангийн аймаг" нэртэйгээр байгуулагдаж, 1934 онд Сэлэнгэ аймаг хэмээн нэрлэжээ.

Аймгийн төв: Сүхбаатар хот
Хэдэн сумтай: 17
Нутаг дэвсгэрийн хэмжээ: 41,152.63 км²
Хүн ам: 107,755 (2019 он)
Угсаатан: Халх
Малын тоо толгой: 1,818,520 (2020)
Утасны код: +976 (0)136
Шуудангийн дугаар: 43000
ТХ-ийн улсын дугаар: СЭ
Цахим хуудас: <https://selenge.gov.mn/>

Сэлэнгэ аймаг нь Монгол улсын хойд хэсэгт Орхон Сэлэнгийн савын дунд зэргийн уулс бүхий нутгийг эзлэн оршино. Аймгийн нутгийн баруун хойд хэсгээр Юрийн хурдас, өмнөд хэсгээр нь герциний боржин, зүүн хэсэгт нь гүний боржин тархжээ. Аймгийн нутагт нүүрс (Улаантолгой, Шарын гол), төмөр (Төмөртэй, Төмөртолгой), алт (Ноёд, Их Алтат, Бугант, Бороо, Заамар, Ноён уул, Толгойт) болон барилгын материалын баялаг бий.

Сэлэнгэ, Орхон, Хараа, Ерөө зэрэг манай орны том гол мөрд урсана. Сэлэнгэ мөрнөөр усан онгоц явна. Цагааннуур зэрэг нуур бий. Ерөө, Товхонханы, Хондын Могойн зэрэг рашаан бий. Нутгийн ихэнх хэсэгт уулын хар шороон хөрс, гол мөрдийн хөндийн хагшаа хурдаст хөрс тархжээ. Мөн Мандал суманд Монгол оронд ургадаг эмийн ургамлын 80% нь ургадаг. Нутгийн уулархаг хэсгээр (42%), ой хөвч тайга, бусад хэсгээр бэлчээрийн ургамал, гол мөрдийн хөндийгөөр шугуй ургажээ. Ойн ба хээрийн амьтад тархсан.



СҮХБААТАР

ХОТЫН ТУХАЙ



Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот Монгол улсын хйоморт оршдог бөгөөд Монголын тулгар төрийн үүсэл хөгжлийн үе үеийн түүхэнд стратегийн түшиц газар болж байснаараа онцлог юм. Оросын худалдаачид 1902 оноос Цагаан-эрэгт ноос угаалгын газар ажиллуулж эхэлсэн ба 1905 оноос угаасан ноос, бусад эд бараагаа Сэлэнгэ, Орхоны голоор тээвэрлэж байсан. 1926 оноос Союзторгфлотын хөлгийг 10 жилийн хугацаатай ашиглах болсноор худалдааны ажил өргөжиж чийдэнгийн хороо, мал авдаг Скотимпорт, Монгол тээх, Ноос угаалгын газар, банк, холбоо, клуб, соёл ахуйн үйлчилгээний том жижиг салбарууд, 1933 онд усан онгоцны зогсоол, 1937 онд Цагаан-Эрэг хотын захиргаа байгуулагдаж Сүхбаатар хотын суурь тавигджээ
Өрхийн тоо: 6,128 (2019)
Хүн амын тоо: 22,505 (2019)
Улаанбаатар хотоос алслагдсан зай: 311 км

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО НҮТБЬ

Тус холбоо нь орон нутгийн аялал жуулчлалын үйлчилгээний байгуулагуудын үйлчилгээний чанар, хүртээмж, төвшинг сайжруулахад чиглэсэн бүхий л ажлыг дэмжин орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба салбарын бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийг нэгтгэн тэдний эрх ашгийг хамгаалах, хүний нөөцийг хөгжүүлэх аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах, аялал жуулчлалын хөгжлийн асуудлаар орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын бодлого чиглэлийг тодорхойлох чиглэлээр төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах болно.

Гишүүдийн тоо: Албан ёсны 16, дэмжигч 15

Байгуулагдсан огноо: 2018

Тэргүүн: Н.Мөнх-Оргил

ҮЗМЭРҮҮД

СЭЛЭНГЭ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

АМАРБАЯСГАЛАНТ ХИЙД

Сэлэнгэ аймгийн Бүрэнхаан уулын өвөрт Ивэн голын эхэнд байдаг. Монголын анхдугаар Богд Г.Занабазарын үйлс, эрдэм билэг, авъяас, ур ухааныг сүсэглэн дээдэлж, түүнд зориулсан хийдийг бариулахаар 1725 онд Манжийн эзэн хаан Энх-Амгалан зарлиг гаргаж улсын сангаас 10 түмэн лан мөнгө гаргажээ. 1726 онд Монголын олон уран дархчуул барилгын ажлыг эхлүүлж тоосго модоор барьж 1737 онд дуусгажээ. Амарбаясгалант гэдэг нэр нь Монгол нэр бөгөөд анх энэ хийдийг байгуулахаар хэсэг лам нар газар шинжиж явахдаа одоо тус хийдийн байгаа газарт эрэгтэй эмэгтэй 2 хүүхэд чулуугаар гэр барин тоглож байсантай тааралджээ. Тэр 2 хүүхдийн нэр нь Амар, Баясгалант гэдэг байжээ. Амарбаясгалант хийдэд сургалтын 10 дацан ажиллаж, хурал ном хурж ид цэцэглэж байхдаа 50 гаруй дугантай, 6000 гаруй лам хуврагтай шашны их орон байжээ. Бурхан багшийн сүм, Аюуш, Махгал, Майдар, Нархажидын сүм, Богд гэгээний ордон, Өндөр гэгээний бунхан зэрэг 40 гаруй сүм дуганыг 175 x 207 метр хэрмэн хашаан дотор барьснаас одоо 28 сүм дуган үлджээ. 1937-1938 оны хэлмэгдүүлэлт хийдийг нөмөрч олон зуун лам нар нь хэлмэгдэн 200 гаруй жилийн турш хуримтлуулж цогцлоосон ховор нандин бурхан шүтээн, судар бүтээлүүд нь дахин сэргээх боломжгүйгээр устгагджээ. Хожим 1943 онд Амарбаясгалант хийдийг улсын хамгаалалтанд авч сэргээн засварласан байна.



ҮЗМЭРҮҮД

СЭЛЭНГЭ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

СОРОНЗОН ХАД

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших дэлхийд ховорхон тогтоцтой хад байдаг нь "Соронзон" юм. Уг хадыг эрт үеэс шүтэн биширч ирсэн төдийгүй уламжлалт анагаах ухаанд ч хэрэглэж иржээ. Нутгийн ардууд Соронзон хаданд ирж үе мөч, гар хөл, нуруу бөөрний өвчнөө засдаг байна. Цус харвасан хүн хүртэл эмчилгээ засал авдаг аж. Харин өвчнөө анагаахын тулд Соронзон хадан дээр хэвтэх, суух, ойр орчмын шороогоор биеэ булах, хажууд нь урсах Төмөртэйн голоос ундаалах зэргээр өөрөө өөрсдийгөө эмчилдэг байна. Энэхүү хад нь бусад хадтай адил энгийн харагддаг ч дэргэд нь очоод ямар нэгэн төмрийн зүйл хүргэхэд соронздон наалдуулдаг байна. Хамгийн сонирхолтой нь цаг зүүсэн хүн очвол цаг нь зогсдог аж. Сүүлийн үед Соронзон хад олны анхаарлын төвд байгаа Төмөртэйн ордын гол цөм хэсэгт байрладаг тул цаашид олборлолт хийгдвэл сүйтгэгдэн үгүй болох аюулд тулаад байгаа. Дэлхийд тун цөөхөн байдаг соронзон орон хүчтэй үүсгэх чадалтай байгалийн хад Монгол орны маань нэгэн бахархал юм.



ҮЗМЭРҮҮД

СЭЛЭНГЭ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ХУВЬСГАЛЫН ӨЛГИЙ АЛТАНБУЛАГ

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших дэлхийд ховорхон тогтоцтой хад байдаг нь "Соронзон" юм. Уг хадыг эрт үеэс шүтэн биширч ирсэн төдийгүй уламжлалт анагаах ухаанд ч хэрэглэж иржээ. Нутгийн ардууд Соронзон хаданд ирж үе мөч, гар хөл, нуруу бөөрний өвчнөө засдаг байна. Цус харвасан хүн хүртэл эмчилгээ засал авдаг аж. Харин өвчнөө анагаахын тулд Соронзон хадан дээр хэвтэх, суух, ойр орчмын шороогоор биеэ булаах, хажууд нь урсах Төмөртэйн голоос ундаалах зэргээр өөрөө өөрсдийгөө эмчилдэг байна. Энэхүү хад нь бусад хадтай адил энгийн харагддаг ч дэргэд нь очоод ямар нэгэн төмрийн зүйл хүргэхэд соронздон наалдуулдаг байна. Хамгийн сонирхолтой нь цаг зүүсэн хүн очвол цаг нь зогсдог аж. Сүүлийн үед Соронзон хад олны анхаарлын төвд байгаа Төмөртэйн ордын гол цөм хэсэгт байрладаг тул цаашид олборлолт хийгдвэл сүйтгэгдэн үгүй болох аюулд тулаад байгаа. Дэлхийд тун цөөхөн байдаг соронзон орон хүчтэй үүсгэх чадалтай байгалийн хад Монгол орны маань нэгэн бахархал юм.



MONTSAMEimages
Baramsai Chadraabal

ҮЗМЭРҮҮД

СЭЛЭНГЭ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ХАЛУУН РАШААН

Сэлэнгэ аймгийн нутагт Хэнтийн ууланд Ерөө голын савд далайн түвшнээс дээш 1150 м-ийн өндөрт оршдог халуун рашаан юм. Карбонат, сульфат, натрийн найрлагатай 42 градусын халуунтай бөгөөд үе мөч мэдрэлийн өвчнийг анагаадаг. Рашаан маань том жижиг 3-н худагтай. Том нь хамгийн халуун. Худагнуудыг чулуугаар хөвөөлж хүн ороход эвтэйхэн болгож янзалсан байдаг.

Халуун рашаан нь 3 хэсгээс бүрдэх бөгөөд хамгийн бага хэмтэй нь шаварлаг бөгөөд 40 хүрэхгүй хэмтэй. Дараагийн хэсэг нь чулуун суурь бүхий 4 хүн хэвтээгээр багтах хэмжээтэй өмнөхөөс илүү хэмтэй юм. Хамгийн халуун буюу 3 дах хэсэг нь 42 орчим хэмтэй. Эдгээр 3 хэсэг нь хэдхэн алхмын зайтай байрладаг. Өвлийн цагт мөстөж, халтирах аюултай. Монгол улсын хамгийн том сум болох Зүүнхараа буюу Сэлэнгэ аймгийн Мандал сумын төв хүртэл 190 км. Зүүнхараагаас Хонин нуга - өвөл гол хөлдсөн үед голоор явах эсвэл Уртын даваа, Хатангийн даваа – Ерөө гол – Шарлангийн голын гарам – Шарлангийн гол – Арижлахийн гол - 50 км явж рашаанд хүрнэ. Нийт замын урт хотоос нэг талдаа 300 км юм.



ҮЗМЭРҮҮД

СЭЛЭНГЭ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ТУЖИЙН НАРС

Тужийн нарс хэмээх байгалийн цогцолбор газар нь 65548.56 га талбайг хамарсан Сэлэнгэ аймгийн Шаамар, Алтанбулаг сумын нутагт байдаг бөгөөд гал түймрийн аюул, ашиг хонжоо хайгчдын гарт өртөн нилээд сүйджээ. Сүүлийн жилүүдэд 7500 орчим га талбайд нөхөн сэргээлт хийсний үр дүнд 40-50% нь байгалийнхаа аясаар сэргэн ургажээ. Тужийн нарс нь байгалийн зүй тогтоцын хувьд өвөрмөц бөгөөд Сибирийн их тайгын зүүн өмнөд төгсгөл, Хэнтийн нурууны салбар уулсын үргэлжлэл болдог. Тужийн нарс нь тэгш тал газрын элсэрхэг хөрстэй нарсан ой бөгөөд эгэл нарс зонхилон ургана. Цагтаа хүн явахын аргагүй шигүү, ойн гүнд нь хээрийн салхины исгэрээ мэдрэгдэхгүй байсан гэгддэг энэ нарсан ой устаж мөхөхийн ирмэгт ирсэн нь саяхан билээ. Тужийн нарсныг экосистемийнх нь хувьд иж бүрэн цогцолбороор нь нөхөн сэргээх зорилгоор 2002 онд УИХ-ын 39 дүгээр тогтоолоор улсын хамгаалалтанд авсан. Тужийн нарс байгалийн цогцолбор газрын нутаг нь Орхон Сэлэнгийн бэлчир орчмын бэсрэг нам уулс, гүвээ толгод бүхий хээр нутаг юм. Уул толгод, ухаа гүвээнүүдийн хажуу нь налуу, хоорондох ам хөндийнүүд нь өргөн. Энд хуурай хээрийн хар хүрэн хөрс голлон тархсан байдаг.



ҮЗМЭРҮҮД

СЭЛЭНГЭ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ЭЭЖ МОД

Сэлэнгэ аймгийн Шаамар суманд орших хүн дүрст модыг "Ээж мод" хэмээн нэрийддэг бөгөөд Улаанбаатар хотоос 310 км зайд оршдог. Ээж мод хэмээн тахиx болсны учир шалтгаан тодорхойгүй бөгөөд зөвхөн таамаг, үлгэр домог л байдаг аж. Эрт үед нэгэн эр ээж модонд сүслэн залбираад явахдаа, татаж байсан тамхиа унтраалгүй явснаас модонд уяатай хадганд гал авалцаж ээж мод шатжээ. Харин өнөөх эр буцах замдаа машинтайгаа онхолдон нас барсан хэмээдэг. Энэхүү догшин үзэгдлийг нутгийн нэгэн алдартай лам аргалахаар болж хажууд нь ургаж байсан модыг аргадан байж одоогийн "Ээж мод" болгосон гэдэг. Тэрхүү шатсан ээж модонд "Хувьсгалын долоо" гэгдэх хүмүүс очиж мөргөөд цааш Улаан Оросоос тусламж авахаар явж байсан гэсэн яриа ч бий. Монголын сүсэгтэн олон жил бүрийн ханш нээх өдрөөр буюу дөрөвдүгээр сард нэг удаа ээж модыг тахидаг ба зорин очсон сүсэгтнүүд ээж модонд сүү өргөж гурван хүслээ гуйдаг юм. Хатуу архийг модруу бус ёроолын элсэнд өргөх ёстой ба хүслээ шивнэхдээ алгаа хавсарч мөргөж болохгүй хоёр алгыг өөд харуулан хүслээ шивнэж гуйдаг байна.



ҮЗМЭРҮҮД

СЭЛЭНГЭ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

САЙХАНЫ ХӨТӨЛ

Сэлэнгэ аймгийн төвөөс 10 хүрэхгүй км-ийн зайтай Монгол Оросын бараг хил дээр байгалийн үзэсгэлэн бүрдсэн Сайханы хөтөл хэмээх сайхан газар бий. Өмнө нь Тэмээн хүзүүтийн хөтөл хэмээн нэрийддэг байсан эл газрыг жанжин Д.Сүхбаатар “Үнэхээр сайхан хөтөл юм аа” хэмээн уулга алдсанаас хойш Сайханы хөтөл хэмээн нэрийдэх болсон гэдэг. Сайхны хөтөлийн байгалийн үзэсгэлэнгийн нэг нь Орхон, Сэлэнгийн бэлчир. Орхон, Сэлэнгэ мөрөн энд нийлж, цааш урссаар Байгаль нуурт цутгадаг. Энд мөн Сайн эрс цуглаж байсан хэмээх агуй ч бий.



MONTSAMEimages
Baramsai Chadraabal

БУСАД ҮЗМЭРҮҮД



ХУЛАН ХАТНЫ ТӨРСӨН НУТАГ

“Монголын нууц товчоо”-нд өгүүлснээр 13 дугаар зууны үед Монголын өнөөгийн хойд хилийн төв хэсэг болох Сэлэнгэ аймгийн нутгаар Хори түмид, Баргажин будгажин, Хэрэмчин, Жүрхэн, Чонос зэрэг гуч гаруй хүчирхэг аймгууд нутаглаж байсны нэг нь Мэргид аймаг байв. Тус аймгийг түүхэнд “Гурван мэргид” хэмээн тэмдэглэн үлдээжээ. Гурван мэргид хэмээхийн учир нь Удуйд мэргид, Увас мэргид, Хаад мэргид хэмээх гурван овгоос бүтсэн Монгол аймгийн нэгэн холбоо байсан бөгөөд Увас мэргидийн тэргүүн нь Дайр-Усун, Удуйд мэргидийн тэргүүн Тогта бэхи, Хаад мэргидийн тэргүүн нь Хаатай Дармала ажгуу.

БУУР ХЭЭРИЙН ТАЛ

Сэлэнгэ аймгийн үзэсгэлэнт газруудын нэг Буур хээрийн талд Монголын тусгаар тогтнолын түүхтэй холбоотой олон үйл явдлууд өрнөж байв. Энэ талд найман зууны тэртээ Чингис хаан Мэргидүүдэд булаагдсан Бөртэ хатнаа эргүүлэн авч Их Монгол Улс байгуулах түүхэн ялалтын эхлэл тавигдсан түүхтэй. Тиймдээ энэ уудам талд нэгэн том чулуун хөшөө сүндэрлэн оршдог. Түүн дээр “Эрсэн хүнээ олсон тул энд бууцгаая хэмээн Чингис хаан айлдав” гэж босоо монгол бичгээр сийлжээ. Тус хөшөөний чулууг Шаамар сумын Дулаанхан тосгоны хойморт залрах “Дулаан Хан” уулнаас авчирч тавьжээ. Басхүү Буур хээрийн талын энэхүү том чулуун хөшөөний урдхан талд дуу дуулахад бургилдаг нэгэн булаг бий.

ДӨРВӨЛЖИН СҮМИЙН ТУУРЬ

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумаас баруун зүгт 3 км зайд, Эрээн нарсны хамар хэмээх газрын зүүн хажууд Дөрвөлжин сүмийн туурь бий. Уг сүм нь Хятад шүтлэгтний сүм байсан бөгөөд тухайн үед Ширээ бурханы сүм гэж нэрлэдэг байжээ. Харин өдгөө тус сүмийн туурин дээр хувьсгалын ялалтад зориулсан дурсгалын хана, пулемёт их бууны хөшөөг босгожээ. Энэ хөшөөг босгосон түүх мөн л 1921 оны хувьсгалын ялалттай холбогдоно. Тухайн үед ардын журамт цэргүүд Дөрвөлжин сүмийн хойт талаас урагшхи газрыг эзэлж авах ёстой байв. Ийнхүү жанжин Д.Сүхбаатарын байлдааны төлөвлөгөө ёсоор цэргүүд 1921 оны 3 дугаар сарын 17-18-нд шилжих үүрээр Дөрвөлжин сүмийн үүднээс 4 пулемётоор гал нээж, гамин цэргүүдийг хөөн Хиагтыг эзлэн авсан түүхтэй билээ.

БУСАД ҮЗМЭРҮҮД

АРДЫН ТҮР ЗАСГИЙН ГАЗРЫН АНХНЫ БАЙР

1921 оны 3 дугаар сарын 13-нд “Монгол Ардын Намын Төв хороо”, “Бүх цэргийн хэргийг Ерөнхийлөн захирах газар”, цэргийн анги, хил орчмын газрын төлөөлөгчдийн хурал болж “Ардын түр засгийн газар”-ыг байгуулсан байдаг. Ийнхүү Ардын түр засгийн газар байгуулсныг Хүрээний засгийн газарт албан ёсоор мэдэгдсэнээр Монголд хоёр засаг тогтож байсан түүхтэй. Ардын түр засгийн газар нь улс орноо харийн түрэмгийлэгчдээс чөлөөлөх тэмцлийг зохион байгуулж удирдах, байнгын засгийн газар байгуулах, Монголын ард түмний төлөөлөгчдийн их хурлыг хуралдуулж Үндсэн хууль цаазыг тогтоох, хөрш зэргэлдээ улсуудтай найрамдалт харилцаа үүсгэн бэхжүүлэх зорилготой улс төрийн байгууллага, ардын ардчилсан төрийн анхны эх үүсвэр байсан юм. Ийнхүү Ардын түр засгийн газар байрлаж байсан хүрэн дүнзэн байшин өдгөө Алтанбулаг сумын нутагт бий. Тус байшингийн зүүн гар талын цонхны хажууд “Ардын намын төв хороо, түр Засгийн газар 1921-3-19-нөөс 1921 -7-р сар хүртэл энд байрлаж байв” хэмээн бичжээ.




Д.СҮХБААТАР ЖАНЖНЫ ХӨШӨӨ

Сэлэнгэ аймагт Д.Сүхбаатар жанжны хэд хэдэн хөшөө баримал бий. Энэ нь мэдээж Ардын хувьсгалын их ялалтанд баатарлаг гавьяа байгуулж, бүх цэргийн жанжнаар өргөмжлөгдсөн түүхэн амжилттай нь холбоотой. Өдгөө Сүхбаатар хотын Нутгийн удирдлагын ордны үүдэнд жанжны алхаж явааг дүрсэлсэн хөшөө буй бол Алтанбулаг сумын музейн хашаанд өндөр баганан дээр залсан “бюст”-ийн цээж баримал бий. Харин Алтанбулаг сумын зүүн урд талын цэцэрлэгт Д.Сүхбаатар жанжинд зориулж босгосон анхны хөшөө эх хувилбараараа хадгалагдаж үлджээ. Энэхүү хөшөө нь дотуур нь төмөр зангидаж, шавраар бүтээсэн буюу улаан зосоор өнгөлж хийсэн хуучны үнэт барималд тооцогдох бүтээл юм.



ГҮН НУУР

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутагт “Гүнж нуур” гэж байдаг бөгөөд эрт цагт уг нуурыг “Гүн нуур” гэдэг байж. Тухайн үед уг нуурын хөвөөн дээр нутаг усандаа өнгө нэмсэн нэгэн сайхан бүсгүй аав ээжийн хамт амьдардаг байжээ. Зан ааль сайтай, үйл үртсэнд уран түүнд нутгийн нь нэг сайхан залуу хайртай болж, бүсгүй ч мөн адил сэтгэл нийлэн ихэд жаргалтай амьдарч байтал алс хошууны засаг ноён бүсгүйн сургийг сонсоод нутагт нь ирж сайхь бүсгүйг эхнэрээ болгохоор шийджээ. Тиймээс бүсгүйг хайртай залуу нь үүр цүүрээр оргуулан авч одсон байна. Гэсэн ч засаг ноёны барлагууд хоёр хосыг барин авч хархүүг хугацаагүй цэргийн албанд цөлж, бүсгүйг есөн цагаан тэмээгээр богтлон авч оджээ. Тэмээн дээр суусан бүсгүй хайртай залуугаа санан зай завсаргүй цурхиран байх зуураа нэгэнтээ ухаан сийлж тэмээгээ Гүн нуурын зүг залсан байна.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД



АМАРБАСГАЛАН ХИЙД ОРЧМЫН БААЗУУД



АМАРБАЯСГАЛАНТ ӨРГӨӨ

📍 Сэлэнгэ аймгийн
Баруунбүрэн сум

☎ 96037886
90097886

🌐 [facebook.com/ Amarbayasgalant Urguu Tour-
ist Camp/](https://facebook.com/AmarbayasgalantUrguuTouristCamp/)

📄 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



МОНОС ТУР

📍 Сэлэнгэ аймгийн
Баруунбүрэн сум

☎ 99112629

🌐 fcaebook.com/monostour/

📄 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



БЭРХ

📍 Сэлэнгэ аймгийн
Мандал сум

☎ 99988488
99047868

🌐 facebook.com/бэрхийнамралт

📄 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД

СҮХБААТАР ХОТЫН ЗООГИЙН ГАЗРУУД



МОДЕРН НОМАДС

- 📍 Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот
- ☎ 70363433
- 📌 Монгол, Европ, Ази хоол www.modernnomads.mn
- 📍 lounge.resistors.showroom 46.2729° N, 102.7790° E



ИХО

- 📍 Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот
- ☎ 85515215
- 📌 Монгол хоол, Европ www.facebook.com/ихо_irish_pub
- 📍 lounge.resistors.showroom 46.2729° N, 102.7790° E



ДЕЛЬФИН

- 📍 Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот
- ☎ 99496868
- 📌 Монгол, Европ хоол www.facebook.com/delfinpub/
- 📍 lounge.resistors.showroom 46.2729° N, 102.7790° E

ЭВЭНТ БАЯР НААДМУУД

АМАРБАЯСГАЛАНТ ХИЙДИЙН ЦАМЫН ХУРАЛ

Зуны сардаа Амарбаясгалант хийд дээр майдар эргэх гэж зан үйл байдаг. Тус хийд 2002 оноос өнөөдрийг хүртэл цам гарсаар ирсэн. Цам маань бурхны шашны зан үйлийг, бурхны дүрийг олон түмэн, сүсэгтнүүддээ таниулах зорилготой зан үйл.

ХУГАЦАА:

Жил бүрийн 9-р сард

ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗАР:

Баруунбүрэн сум,
Амарбаясгалант хийд

ХӨТӨЛБӨР:

- Бурхны шашны сүсэгтэн шавь нар, эргэлчин мөргөлчин нар хийдийн хурал номын үйлд оролцон буян хураах

-300-аад жилийн түүхтэй "Амарбаясгалант" хийдийн хосгүй үнэт бүтээлүүдтэй танилцуулах

-Шашны зан үйлүүд болон урлаг соёлын өв болох Майдар эргэх, Цам харайх, Бумба тахих ёслолыг үзэж, буян хураах.



ЭВ МОДНЫ НААДАМ

Монголын харуулын занги, Оросын хилийн атаман нар тус бүрдээ хадгалдаг хоёр хэсэг модоо эвээр нь нийлүүлэх "Эв мод нийлүүлэх" энэхүү ёс анх 1774 онд бий болжээ. Эртний уламжлалыг сэргээн 2003 оноос энэ наадмыг хоёр тал ийнхүү зохион байгуулдаг болсон түүхтэй. Энэ наадам нь жил бүр Орос, Монголын нутаг дэвсгэр дээр ээлжлэн зохион байгуулагддаг бөгөөд наадамд хоёр орны хилийн бүс нутгийн оршин суугчид оролцдог юм.

ХУГАЦАА:

Жил бүрийн 7-р сард

ХААНА:

Алтанбулаг сум, хилийн бүс

ХӨТӨЛБӨР:

Эв модны наадамыг албан ёсоор нээхээс өмнө эртний уламжлалт ёсыг бэлгэдэн Орос, Монголын хилийн морьтон харуулууд туг намируулан, хоёр талын хадгалдаг эв модны хэсгүүдийг цэнгэлдэх хүрээлэнд залан авчирсны дараа Сэлэнгэ аймгийн Засаг дарга, ОХУ-ын Буриад улсын Хиагтын аймгийн дарга нар наадамчин олонд мэндчилгээ дэвшүүлнэ.



ЭВЭНТ БАЯР НААДМУУД

СЭЛЭНГЭ УРГАЦЫН БАЯР

Эх нутгийнхаа хөрсөнд ургасан үр тариа, төмс хүнсний ногоо, таримал ургамлаар Монгол түмнээ хангах эрхэм үүргийг хүлээсэн Сэлэнгийн тариаланчид, энэ хүмүүстэй сэтгэл зүтгэлээрээ холбогдсон нийт түмэн олонд зориулсан "Ургацын баяр" арга хэмжээ 12 дугаар сард Сүхбаатар суманд зохион байгуулагддаг.

ХУГАЦАА:

Жил бүрийн 12-р сард

ХААНА:

Сүхбаатар сум, Сэлэнгийн долгио чуулгын байр

ХӨТӨЛБӨР:

- Нэгж га талбайгаас хамгийн их улаанбуудайн ургац хураан авч тэргүүлсэн сум
- Нэгж га талбайгаас хамгийн их төмс хураан авч тэргүүлсэн сум
- Нэгж га талбайгаас хамгийн их хүнсний ногоо хураан авч тэргүүлсэн сум
- Газар тариалангийн салбарт хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгж
- Нэгж га талбайгаас хамгийн их улаанбуудайн ургац хурааж тэргүүлсэн аж ахуйн нэгж
- Хамгийн их жимс жимсгэнэ



**МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО, СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБООТОЙ ХАМТРАН ЗОХИОН
БАЙГУУЛАХ “СЭЛЭНГЭ” ТАНИЛЦАХ АЯЛАЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

SELENGE TOUR -2019
аялалын маршрут /2019.09.20-09.24/

ЗОРИЛГО:

Сэлэнгэ аймгийн байгалийн үзэсгэлэн, түүх соёлын дурсгал, аялал жуулчлалын нөөц, аялал жуулчлалын бааз, амралтын газар зочлох үйлчилгээний салбарын хүчин чадлыг тодорхойлж зохистой ашиглах, аялал жуулчлалын шинэ зах зээлийг бий болгох, сурталчлах, мэргэжлийн чадварлаг тур операторуудтай хамтран ажиллах, туршлага судлах, орон нутагт тогтвортой аялал жуулчлалыг дэмжих.

ЗОРИЛТ:

Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын маршрут, байгаль түүхийн дурсгал, олон голын сав газрын үзэсгэлэн, ургамал амьтны төрөл зүйл, уламжлалт аж ахуй зэрэг аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц, боломжийг Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэгч аялал жуулчлалын байгууллагууд тэр бүр мэддэггүй. Газар зүйн байрлал, дэд бүтэц, орон зайн хувьд өөрийн онцлог давуу талтай Сэлэнгэ аймаг нь аялал жуулчлалын салбарын нэгэн зорилтот зах зээлийг бий болгох бүрэн боломжтойг таниулан сурталчлах шаардлагатай байна. Сэлэнгэ аймгийн хувьд Олон Улсын чанартай автозамаар дамжин өнгөрөх зорчигч, жуулчдад үзүүлэх аялал жуулчлалын үйлчилгээ, бүтээгдэхүүнээс гадна нутгийн гүнрүү чиглэсэн тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэн хүний нөөцийг чадавхжуулах замаар эдийн засгийн үр өгөөжтэй гадаад, дотоодын жуулчдын зорин ирдэг орон нутаг болох зорилтыг нэн тэргүүнд тавьж байна.

АЧ ХОЛБОГДОЛ:

Мэргэжлийн шинжээчид, гэрэл зурагчид, аялал жуулчлалын туршлагатай тур операторуудтай хамтран ажиллана. Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын маршрутыг танилцуулах, шинэ зах зээлд бизнес түншлэл хамтын ажиллагааг бэхжүүлэх боломжтой.

ХАМРАХ ХҮРЭЭ:

Тур оператор компани захирал, аялалын менежерүүд.

АЯЛАЛЫН МАРШРУТ:

“Сэлэнгэ” танилцах аялал нь Сэлэнгэ аймгийн Сайхан, Сант, Баруунбүрэн, Хушаат, Зүүнбүрэн, Шаамар, Цагааннуур, Түшиг, Сүхбаатар, Алтанбулаг, Ерөө, Жавхлант, Баянгол, Мандал сумдын нутгаар 5 өдөр, 4 шөнө үргэлжилнэ.

ЗАРДАЛ:

Аялалд нийт 15-н хүн бүртгэх бөгөөд 2 фургон машинаар явна. Аялалын жолоочын зардал, бензин, хоолны зардал.

ХУГАЦАА:

9 сарын 20-оос 24-н хүртэл Сэлэнгэ аймгийн жуулчны бааз, амралтын газруудад хоноглоно.

АЯЛЫН ТОВЧ ХӨТӨЛБӨР

09 сарын 20-нд

Өглөө 8.30-д Драгон төвөөс хөдөлнө. Баянгол суманд өдрийн хоол идэн Орхон сумын нутагт байх Хүн чулуун хөшөө, 2-р богд өндөргэгээний төрсөн газар, нийслэл хүрээ байрлаж байсан газар болон эртний Солонгосын цаасны үйлдвэр байсан туурийг үзэн Бурхантай хад зэргийг үзэн Амарбаясгалант хийд дээр очно. IF toug Амарбаясгалт жуулчны бааз дээр хоноглоно.

09 сарын 21-нд

Өглөөний цайны дараа Хушаат сумын нутаг руу хөдлөн замдаа Цармын эрээн, Нийслэл хотын туурь, Дуут хад, Түргийн үеийн хирэгсүүр зэргийг үзэн Зүүнбүрэн сумын нутгаар дайран Цагааннуур сумын усны шувууд ихтэй Цагааннуурыг үзэн Түшиг сумын Баруунмоностой хэмээх үзэсгэлэнт газар SND Murgun амралтын газар хоноглоно.

09 сарын 22-нд


Сүхбаатар хотыг зорин Сайханы хөтөл, Буур хээр, Хоёр элс, Гүн нуур, Хонд, Тужын нарс зэрэг түүхийн болон байгалийн үзэсгэлэнт газруудаар аялана. Энэ өдөр Сэлэнгэ аймгийн удирдлагууд болон БОАЖ газрын дарга нартай уулзана.

09 сарын 23-нд

Дулаанхан тосгонд байрлах 7-н үеэрээ нум сум урлаж буй Хөвчит нум компаний үйл ажиллагаатай танилцан цааш хөдлөн Ерөө сумын нутагт байрлах Соронзон хад үзэн цааш Зүүнхараа, Түнхэл тосгонд байрлах Ноён уулын бэлд байх амралтын газар хоноглоно.

09 сарын 24-нд

Үдээс өмнө Ноён уулаар морин аялал хийнэ. Өдрийн хоолны дараагаар Улаанбаатар хотыг зорисноор танилцах аялал өндөрлөнө.



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АЯЛЛЫН МАРШРУТ**